



USAID
FROM THE AMERICAN PEOPLE



Economic Policy Reform and
Competitiveness Project

ЭЗБШӨЧ ТӨСЛИЙН САР ТУТМЫН ЦУВРАЛ

2009 оны 8, 9 дүгээр сар

Монголын Ипотекийн корпорацитай тус улсад анх удаа 10 тэрбум төгрөгийн ипотекийн бонд гаргалаа

2009 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр Монголын Ипотекийн корпорацитай (МИК) тус улсын Санхүүгийн зохицуулах хороонд 25 тэрбум төгрөгийн бонд гаргаж байгаагаа бүртгүүлэн, мөн өдөртөө 10 тэрбум төгрөгийн бондын арилжаа хийлээ. Бондын хөрөнгө оруулагчид нь МИК-ийн хувьцаа эзэмшигч арилжааны банкууд болох Худалдаа, хөгжлийн банк, Капитрон банк, Хас банк байв.



Бондын орлогыг дээрх гурван банкнаас ипотекийн зээл худалдан авахад шууд зарцуулсан байна. Энэхүү арилжаа нь Монголын банкны байгууллагууд, АНУОУХА, МИК-ийн дөрвөн жилийн хамтын ажиллагааны үр дүн байсан бөгөөд энэ нь тус улсын зохих байгууллагаар бүртгүүлэн гаргасан дунд хугацааны ипотекийн бондыг арилжаалсан анхны трансакци болсон юм. Энэ трансакци нь орон сууцны барилгыг санхүүжүүлэх, иргэд боломжийн үнээр өөрийн орон сууцтай болох урт хугацааны хөрөнгийн эх үүсвэр, хөрвөх хөрөнгийг тус улсын хөрөнгийн зах зээлд бий болгон, түүний хөгжлийг урагшлуулсан чухал алхам болов.

Ерөнхий сайдын Ажлын албаны хүсэлтээр ЭЗБШӨЧ төслөөс 2005 оны 9 дүгээр сард орон сууцны санхүүжилтийн салбарын талаар судалгаа хийж, ипотекийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн хөгжил, Засгийн газрын "40,000 айлын орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үүний дотор бага орлоготой иргэдэд орон сууцны санхүүжилтийг хүртээмжтэй болгох, тус улсын ипотекийн хоёрдогч зах зээлийн хөгжлийг дэмжих зорилгоор эл зах зээлд ажиллах санхүүгийн байгууллагыг байгуулах талаар зөвлөмж гаргасан юм.

Дээрх зөвлөмж болон өмнө нь хийгдсэн бусад ажлуудад тулгуурлан ЭЗБШӨЧ төслөөс арилжааны банкууд, Монголбанкныг (МБ) оролцуулсан гурван удаагийн уулзалт зохион байгуулахад туслалцаа үзүүлсэн ба эдгээрийн үр дүнд 2006 оны 3 дугаар сарын 20-ны өдөр арилжааны 9 банкнаас

(Хаан банк, Анод банк, Голомт банк, Монгол Шуудан банк, Худалдаа, хөгжлийн банк, Зоос банк, Капитрон банк, Капитал банк) орон сууцны санхүүжилтийн байгууллага байгуулах зорилгоор Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, санал болгож буй шинэ байгууллагыг байгуулах бэлтгэл ажлыг хангах, үйл ажиллагааг нь тодорхойлох, бүтэц, зохион байгуулалт, түүнчлэн эл байгууллагыг өөрийн хөрөнгөтэй болох хүртэл санхүүжүүлэх асуудлуудыг хариуцсан Ажлын хэсэг байгуулан, Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ), удирдлагын багаа томилсон юм. Шинээр байгуулагдсан байгууллагыг Монголын Ипотекийн корпорацитай (МИК) гэж албан ёсоор нэрлэсэн юм.

2006 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр арилжааны 10 банк (өмнө нь байсан 9 банк дээр Улаанбаатар банк нэмэгдсэн) болон МБ хөрөнгийн хоёрдогч зах зээлд ажиллах МИК гэж товчоор нэрлэгдэх болсон ипотекийн компанийг үүсгэн байгуулах тухай гэрээ байгуулав. ЭЗБШӨЧ төсөл уг байгууллагыг байгуулахад зөвлөхийн үүрэг гүйцэтгэн, МБ, арилжааны банкуудтай хамтран ажилласан юм. МБ, арилжааны банкууд МИК-д тус бүр 1 сая төгрөгийн хөрөнгө оруулж, дүрмийн санг 11 сая төгрөгөөр бүрдүүлж, энэ хэмжээгээр тус компанийн эн тэнцүү хувьцаатай болсон байлаа.

Компанийг үүсгэн байгуулах тухай гэрээнд түүний үндсэн үйл ажиллагааг ипотекийн хоёрдогч зах зээлийн хөгжлийн үндэс суурийг тавих; уг компанийн үнэт цаасыг борлуулах, мөн шууд зээлдэгчийн хувьд дундаас урт хугацааны хөрөнгө босгоно гэж заажээ. Түүнчлэн, тус компани нь ипотекийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн хөгжлийг дэмжих; ипотекийн анхдагч зах зээлд зээл олгохтой холбоотой андеррайтерийн бодлого, баримт бичгүүдийг стандартчилах; өөрийн үндсэн үйл ажиллагаагаа дэмжих нээлттэй зах зээлийн үйл ажиллагаа явуулах; үнэт цаастай холбоотой үйлчилгээ үзүүлэх; ипотекийн зээлийн барьцааны зүйлийг шүүхийн бус журмаар борлуулахад зайлшгүй шаардагдах эрх зүйн хийгээд зохицуулалт, бүтэц зохион байгуулалтын асуудлаар Засгийн газартай хамтран ажиллах юм.



Компанийг үүсгэн байгуулах тухай гэрээнд гарын үсэг зурсны дараа, мөн МИК-ийг албан ёсоор байгуулсан эхний үед

Энэхүү цувралд нийтлэгдсэн санаа бодол нь АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг болон АНУ-ын Засгийн Газрын байр суурийг заавал илэрхийлсэн байх албагүй болно.

ЭЗБШӨЧ төслөөс техникийн болон зөвлөх үйлчилгээний техникийн туслалцааг үргэлжлүүлэн үзүүлсээр байсан бөгөөд тус компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчийн орон тоонд монголын мэргэжлийн багийг ахлан ажиллаж, андеррайтерийн бодлого, журам, ипотекийн стандарт баримт бичиг, зээлийн багцын менежмент, ипотекеэр баталгаажсан үнэт цаас гаргах журам зэргийг боловсруулахад удирдамж чиглэл өгч ажиллав. Тус төслийн техникийн туслалцааны хүрээнд хоёр зөвлөх урьж МБ, МИК-д ажиллууллаа. Үнэт цаасны зах зээлийн трансакцийн асуудлаар олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн эксперт Монголбанкинд үнэт цаасжуулалтын зөвлөхөөр ажиллалаа. Хөрөнгө оруулалтын банкир, Fannie Mae корпорацид ажиллаж байсан ахлах мэргэжилтэн МИК-ийн зөвлөхөөр ажиллаж, тус корпорацийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч болон ТУЗ-тэй хамтран компанийн бүтэц бүрэлдэхүүн, хороодын үүрэг, хариуцлагын талаархи баримт бичгийг эцэслэн боловсруулсан юм.

МИК-ийг хуулийн этгээдээр бүртгүүлэн аж ахуйн нэгжийн гэрчилгээ авсан 2006 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр тус корпораци өөрийн оффисоо албан ёсоор нээж, www.mik.mn домайнаа бүртгүүлэв. 2007 оны 6 дугаар сарын 20-ны өдөр тус корпорацийн хувьцаа эзэмшигчид тусгай хуралдаан зарлан хуралдуулж, МИК-ийн хөрөнгийг 2.2 тэрбум төгрөгт хүртэл нэмэгдүүлэх шийдвэрийг санал нэгтэй баталж, оруулах хөрөнгийн хэмжээг тогтоон санал болгосны дагуу одоогийн хувьцаа эзэмшигчид уг хөрөнгийг дангаараа бүрдүүлсэн юм. 2007 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр болсон ёслолын арга хэмжээний үеэр МИК-ийн ТУЗ-ийн дарга хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа нэмэгдүүлснийг баталгаажуулах гэрчилгээг тэдэнд гардууллаа.



МИК-ийн хөрөнгө нэмэгдсэн, мөн ЭЗБШӨЧ төслийн зөвлөмжөөр 2007 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр МИК анхны арилжаа хийж, Хас банкнаас 1,033,898.04 ам.долларын ипотекийн шалгуурт нийцсэн зээлийн багц худалдан авсан нь Монгол улсад ипотекийн хоёрдогч зах зээлд хийгдсэн анхны гэрээ хэлэлцээр байсан юм. Энэ арилжааны дараа 19 сарын хугацаанд МИК 4.1 тэрбум төгрөгийн үнэ бүхий 5 багц, хамгийн сүүлд буюу 2009 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр 10 тэрбум төгрөгийн ипотекийн багц худалдан аваад байна.

2007 оны 11 дүгээр сард хийсэн ипотекийн анхны худалдан авалтаас хойш МИК ашигтай ажиллах болж, ипотекийн харьцангуй том багцыг үнэлэх, худалдан авах, менежмент хийх чадавхитай боллоо. Зохих байгууллагад бүртгүүлж гаргасан МИК-ийн 25 тэрбум төгрөгийн бонд нь тус улсын ипотекийн зах зээлд ихээхэн шаардлагатай байгаа хөрвөх хөрөнгийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хөрөнгийн хоёрдогч зах

зээлд амжилттай ажиллаж буй Монгол улсын анхны компанийн үйл ажиллагаанд оролцох хөрөнгө оруулагчдад таатай боломж олгох замаар тус улсын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд зохих хувь нэмэр оруулж байна.

2009 оны Жуумла! Монгол Өдөр-ийн арга хэмжээний үеэр Жуумла! 1.5 Монгол хувилбарыг албан ёсоор гаргалаа

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар (МШХХТГ)-тай хамтран 2009 оны 9 дүгээр сарын 29-30-ны өдрүүдэд зохион байгуулсан Жуумла! Монгол Өдөр арга хэмжээг ЭЗБШӨЧ төсөл ивээн тэтгэлээ. Жуумла! Монгол Өдөр-ийн арга хэмжээ нь тус улсын төрийн, бизнесийн, иргэний нийгмийн байгууллагууд, иргэдийг хэрэглэгчид ээлтэй, боломжийн арга замаар интернетээр дамжуулан хэрэгцээт мэдээллээр хангах, мөн тэдэнтэй харилцах нээлттэй эхэд тулгуурласан агуулгын удирдлагын системийг (АУС) монгол хэлнээ бүрэн хөрвүүлж боловсруулахад зарцуулсан хоёр жилийн хөдөлмөр, уг ажлыг хийж гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлсэн ЗГХЭГ, МШХХТГ-ын хамтын ажиллагааны үр дүн байлаа.

Агуулгын удирдлагын систем нь вэбсайтад байгаа агуулгын хэсэг тус бүрийг бүртгэж хадгалдаг программ хангамж юм. Агуулга нь ердийн текст, фото зураг, дуу хөгжим, видео, баримт бичиг гэх мэт таны төсөөлж болох бүх зүйл байж болно. АУС-ийг ашиглах хамгийн гол давуу тал бол түүнийг ажиллуулахад техникийн өндөр ур чадвар, мэдлэг бараг шаардахгүй учраас янз бүрийн ажил мэргэжлийн бүх монголчуудад интернетээс авах мэдээллээ нэмэгдүүлж, харилцаа холбооныхоо технологийг сайжруулах боломж олгож байгаад оршино.



Жуумла! нь хэрэглэгчдэд вэбсайтаа зохиох, удирдах, ажиллуулах, улмаар онлайн хүчин чадал сайтай орчин үеийн хэрэглээний программыг ашиглах боломж олгодог АУС-үүдээс шилдгээр шалгарч шагнал хүртсэн АУС юм. Жуумла! нь нээлттэй эхийн шийдэлтэй, хүн бүр үнэгүй ашиглах боломжтой, бүх хүнд зориулагдсан систем бөгөөд түүний хэрэглэхэд хялбар байдал, ажиллагааг нь өргөжүүлэх боломж болон бусад олон төрлийн шийдлүүд нь уг системийг АУС-ийн хамгийн түгээмэл хэрэглэдэг программ хангамж болгож чаджээ.

2007 онд Жуумла! 1.0 Монгол хувилбарыг албан ёсоор гаргаснаас хойш тус улсын төрийн байгууллагуудын 200 гаруй вэбсайт Жуумла!-г ажиллуулах болжээ. Энэ системийг ажиллуулснаар төрийн байгууллагууд иргэдтэй илүү үр дүнтэй харилцах болж, иргэдэд шаардлагатай мэдээллээ олж авах боломж бололцоог илүү сайн бүрдүүлж өгч чадсан юм.

Төрийн байгууллагуудаас гадна Монгол улсын 13,200 гаруй вэбсайт *Жуумла!*-г ажиллуулж байна. Шинэчлэн боловсруулсан *Жуумла! 1.5 Монгол хувилбар* нь өмнөх *Жуумла! 1.0, 1.1 Монгол хувилбаруудыг* сайжруулж боловсронгуй болгосон, монгол хэлнээ 100 хувь хөрвүүлсэн хувилбар болж, монголчуудад АУС-ийг илүү өргөн хүрээнд ашиглан интернетээс авах мэдээллээ нэмэгдүүлэх боломж олгож байна.

Монгол улсын хэмжээнд *Жуумла!*-д суурилсан вэбсайтын хэрэглээ улам бүр өргөжиж, алдаршиж байгаа нь уг системийг төрийн байгууллагуудад нэвтрүүлэхийг сайшааж, дэмжлэг үзүүлж буй тус улсын ЗГХЭГ, мөн *Жуумла! Монгол* хувилбарыг байнга сайжруулж, боловсронгуй болгон үр дүнтэй сурталчилж буй МШХХТГ, ЭЗБШӨЧТ төслийн ажлын үр дүнтэй холбоотой юм.

Жуумла! Өдөр-ийн арга хэмжээний эхний өдөр 143 хүн, хоёрдох өдөр 102 хүн оролцов. Тус арга хэмжээнд МУИС, Тур Монгол ХХК, Мэдээллийн технологи, харилцаа холбооны дээд сургууль, Элэком ХХК, Aptech World Wide Монгол, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн их сургууль, Инженерсофт ХХК, Хэвлэлийн хүрээлэн, Санхүү, эдийн засгийн дээд сургууль зэрэг төрийн байгууллага, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн компаниудын төлөөлөл оролцлоо.

Жуумла! Монгол Өдөр нь дэлхий нийтийн хэмжээнд зохион байгуулагддаг *Жуумла!*-гийн хамгийн том арга хэмжээ юм. 2009 онд гэхэд л АНУ, Их Британи, ХБНГУ, Франц, Тайланд, Австрали, Канад, Энэтхэг, Итали, Шинэ Зеланд, Филиппин, Турк улсад энэ арга хэмжээг зохион байгуулаад байна.



2009 оны *Жуумла! Монгол Өдөр-ийн* арга хэмжээний үеэр *Жуумла! 1.5 Монгол хувилбарыг* албан ёсоор гаргаж, уг программ хангамжийн хэрэглээ, шинэчлэгдсэн зүйлүүдийн талаар хэрэглэгчидтэй уулзаж ярилцах, хамтдаа суралцах, санал бодлоо солилцох боломж олгосон юм. Уг арга хэмжээний албан ёсны нээлтийн ажиллагаанд Монгол Улсын Сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Долгор, АНУ-д төвтэй *Жуумла!*-гийн Үндсэн багийн гишүүн Райн Озимек, ЭЗБШӨЧ төслийн удирдагч Фернандо Бертоли нар үг хэлэв. *Жуумла! Монгол Өдөр-ийн* арга хэмжээний хүрээнд сургалт, семинар явагдсанаас гадна ЭЗБШӨЧ төслийн МТ-ийн мэргэжилтэн Т. Алтансүх шинээр боловсруулсан *Жуумла*

1.5 Монгол хувилбарын талаар презентаци тавьж, ажиллуулж үзүүлээ.

Жуумла 1.5 Монгол хувилбарыг Монгол орчуулгын багийн <http://www.n20.mn>. вэбсайтаас татаж авч болно. Монгол орчуулгын баг нь өөрсдийн цаг заваа гаргаж, МТ-ийн илүү сайн шийдлийг монголчуудад зориулан бий болгохыг зорьж сайн дурын үндсэн дээр ажиллаж буй хүмүүс, оюутнууд, программ зохиогчдоос бүрдэж байна. ЭЗБШӨЧ төслийн хувьд олон нийтийн зүгээс мэдээлэл олж авах боломж, мэдээллийг ил тод болгох стандартыг сайжруулахын тулд *Жуумла-гийн шинэ хувилбарыг* илүү боловсронгуй болгох, мөн төрийн байгууллагуудын вэбмастеруудад сургалт явуулах чиглэлд үзүүлж буй дэмжлэгээ үргэлжлүүлэх юм.

Гаалийн эрсдэлийн удирдлагын хөтөлбөр хэрэгжиж эхлэв

Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэх, Азийн Хөгжлийн Банк (АХБ)-аас хэрэгжүүлж буй гаалийг шинэчлэх төслийн хүрээнд болон хилийн мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг нэгтгэх чиглэлд анхны алхам болох гаалийн эрсдэлийн удирдлагын системийг (ГЭУС) нэвтрүүлэхэд туслалцаа үзүүлэх хүсэлтийг ГЕГ-аас ЭЗБШӨЧ төсөлд тавьсан юм. Уг төслөөс Цахим нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлж байгаа бөгөөд өнгөрсөн жил Замын-Үүдийн хилийн мэргэжлийн хяналтын газрыг компьютержүүлэх талаар МХЕГ-тай хамтран ажилласан билээ. Мөн Замын-Үүдийн хилийн мэргэжлийн хяналтын газрын гар ажиллагааг арилгаж, ГЕГ-ын ГАМАС системд холбогдох боломжийг бүрдүүлэх дотоод сүлжээг суурилуулж, ашиглах чиглэлээр ЭЗБШӨЧ төслийн зүгээс МХЕГ-т туслалцаа үзүүлж байгаа болно.

ГЭУС-ийг нэвтрүүлснээр ГЕГ нь хяналт болон худалдааг хөнгөвчлөх асуудлын хооронд зохистой балансыг бий болгож, бүх ачааг 100 хувь шалгах бус зөвхөн эрсдэлийн профайлын системээр тогтоосон ачаа, барааг шалгадаг байх зарчмыг баримтлахыг эрмэлзэж байгаа юм. Үүний тулд ГЕГ саяхан Эрсдэлийн удирдлагын албыг (ЭУА) байгуулж, ажилтнуудыг томилсон байна.

Олон улсын гаалийн зөвлөх Хорхе Монтоягийн дэмжлэгтэйгээр уг төслөөс ЭУА байгуулж, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх шаталсан төлөвлөгөөг боловсруулахад ГЕГ-т тусалж байгаа юм. 2009 оны 9-р сарын 3-нд ГЕГ-аас семинар зохион байгуулж тус байгууллагаас хийсэн үнэлгээний ажлын үр дүн болон ГЭУ-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хэлэлцэж, санал солилцлоо.



Семинарыг хоёр хэсэгт хуваан явуулав. Эхний хэсэгт ГЭУС-ийг нэвтрүүлэх үе шат, ГЕГ-ын холбогдох газар, хэлтэс болон орон нутаг дахь гаалийн газар, хороод, гаалийн зуучлагчдын үүрэг роль, тэдний гүйцэтгэх үйл ажиллагааны талаар тайлбарлав. Үүнээс гадна ГЭУС-ийг нэвтрүүлэхэд шаардлагатай бүрэлдэхүүн хэсгүүдэд анхаарал хандуулав: судалгаа хийх, профайл үүсгэх, шалгууруудыг тогтоож анализ хийх, санал солилцох, эрсдэлийн тэмдэглэл (улаан, шар, ногоон) тавих г.м. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд ГЕГ-ын бүх газар, хэлтэс, хувиараа худалдаа эрхлэгчид, зуучлагчид, МХЕГ-ын байцаагч нар зэрэг бүх оролцогч талуудын хамтын хүчин чармайлт нэн шаардлагатай бөгөөд цаашид нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой энгийн загварыг ашиглах нь зүйтэй.

Бодит жишээн дээр даалгавар өгч ажилтнуудын техникийн ур чадварыг сайжруулахад семинарын хоёр дахь хэсэг чиглэгдэв. Даалгаврыг гүйцэтгэхэд Эрсдэлийн удирдлагын албаныхан хилийн боомтуудаас ирүүлсэн судалгааны мэдээллүүдийг ашиглаж янз бүрийн компани, бараа бүтээгдэхүүний эрсдэлийн түвшинг тогтоолоо. Дараа нь эрсдэлийн өгөгдөхүүн мэдээлэлд үндэслэн тодорхой компани, бүтээгдэхүүнээр профайл үүсгэн шалгууруудыг тогтоож, эдгээр шалгууруудын дагуу гаалийн шалгалт хийх тэмдэглэгээг хэрхэн тавихыг үзүүлж туршсан болно. Үүнээс гадна ЭУА болон мэдээллийн технологийн ажилтнууд техникийн зарим асуудлын талаар ярилцаж, санал солилцож, хэрхэн профайл үүсгэх, шалгууруудыг тогтоох, нэмэх, өөрчлөх, судалгааны дүнг хэрхэн хянах мөн тухайн ачаа барааны эрсдэлийн магадлалыг хэрхэн тооцох кейс жишээнүүд дээр ажилласан болно.

ЭУА, Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн хэлтэс, Санхүү, эдийн засгийн хэлтэс, Мэдээлэл технологийн төв, Статистик, дүн шинжилгээний хэлтсийн ажилтнууд болон ахлах байцаагч нар нийт 14 хүн семинарын эхний хэсгийн үйл ажиллагаанд оролцсон бол хоёр дахь хэсгийг зөвхөн ЭУА, МТТ-ийн ажилтнуудад зориулж явуулав.

ГЕГ-аас тавьсан хүсэлтийн дагуу зөвлөх Монтоя 10 дугаар сард дахин ирж судалгаа болон эрсдэлийн профайл үүсгэх ажлыг сайжруулах мөн ЭУА-ны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд туслахаар болов. Үүний зэрэгцээ гаалийн зуучлагчдын үйл ажиллагааг олон улсын стандарт, Гаалийн тухай хуулийн дагуу явуулах хөтөлбөрийг боловсруулах ажилд уг төслийн зүгээс ГЕГ-т тусалцаа үзүүлэх юм.

Монголын Компанийн Засаглалын хөгжлийн төвд хамтарсан санхүүжилт хийв

Монголын Компанийн засаглалын хөгжлийн төв (МКЗТ) энэ оны 6 дугаар сарын 2-ны өдөр байгуулагдсанаас хойш 50 гаруй мэргэжлийн хүмүүс, 10 байгууллага тус төвийн гишүүнээр элсжээ. ЭЗБШӨЧ төслийн багтай хамтран ажилласны үр дүнд МКЗТ нь ХААН Банк, Мобиком корпораци, Энержи ресурс ХХК-аас тус бүр 5000 ам.долларын хандив авах боломж бүрдэв. Энэхүү хандив нь тус төвийн тогтвортой хөгжилд чухал тус дөхөм болох бөгөөд үүнийг үйл ажиллагааны зардал, үйлчлүүлэгч компаниудад зориулсан хөтөлбөр боловсруулах, зөвлөх үйлчилгээтэй холбоотой зардал зэрэг эхний үед авах шаардлагатай арга хэмжээнд зарцуулах юм. МКЗТ-ийн гишүүн зөвлөхүүд сургалтын тусгай хөтөлбөр боловсруулах, ивээн тэтгэгч компаниудад компанийн засаглалын үнэлгээ хийх ажилд тусалцаа үзүүлнэ. АНУ-ын ОУХАгентлагаас санхүүжүүлдэг ЭЗБШӨЧ төслийн зүгээс 25000 ам.долларт багтсан санхүүжилтийн тусалцаа үзүүлэхээр тохирлоо.


Банкны эрх зүйн хүрээнд үнэлгээ хийлээ

Монгол Банкны хүсэлтийн дагуу, мөн төслийн зөвлөх Роберто Тосогийн тусалцаатайгаар ЭЗБШӨЧ төсөл 2009 онд 9 дүгээр сард тус улсад үйлчилж буй Банкны тухай хууль, Төв банкны тухай хуулийг нягтлан судалж, олон улсын шилдэг туршлагад нийцүүлэн зохих нэмэлт өөрчлөлт оруулсан төсөл боловсруулан санал болгоод байна. Банкны тухай хуулийг Базилийн Банкны үр дүнтэй хяналтын үндсэн зарчмуудын (1997 оны 9 дүгээр сар) гол бүрэлдэхүүн хэсгүүдтэй харьцуулан, эдгээр стандартад хамаарах тус улсын үзүүлэлтүүдийг харгалзан нягтлан судаллаа.

Сайтар боловсруулсан зохицуулалтын хүрээ нь банкны хянан шалгагчдад банкны хүндрэлтэй асуудлуудын шинж чанар, шалтгааныг өөр хооронд нь ялгах боломж олгодог. Түүнчлэн, банкны тухай хууль нь банкны хянан шалгагчдад хүндрэлтэй асуудлыг ноцтой болохоос өмнө эхний шатанд нь олж тогтоон, зохих арга хэмжээ авах удирдамж болох ёстой. Банкны тухай хуульд хянан шалгагчдын зүгээс хурд, зардал үр ашиг, уян хатан, нийцтэй, ил тод байдал, хамтын ажиллагаа, ёс суртахууны эрсдэлээс зайлсхийх зарчмуудад тулгуурласан шуурхай арга хэмжээ авах үүрэг хариуцлагыг маш тодорхой зааж өгсөн байвал зохино.

Монгол Улсын Банкны тухай хуулийг дээрх агуулгаар чангатгаж, сайжруулахад дараахь зөвлөмжийг өгч байна. Үүнд:

- Банкны хувьд холбогдох этгээдтэй холбоотойгоор гарч болох дарамт, сонирхлын зөрчилтэй холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор "холбогдох этгээдийн хэлцэл" гэх тодорхойлолтыг илүү ойлгомжтой томъёолж, энэ талаархи журмыг чангатгах
- Эрх зүйн зохицуулалтыг дагаж мөрдөх явдлыг сахиулах
- Банкны өөрийн хөрөнгийн шаардагдах хамгийн доод хэмжээг нэмэгдүүлэх
- Банкууд нэгдэх, банк худалдан авах журам
- Мэдээллийн ил тод байдал, тайлагналыг сайжруулах
- Нэгдсэн хяналт шалгалтыг чангатгах
- Банкны эрх хүлээн авагч томилсон үед шүүхээс гадуур болон шүүхийн журмаар төлбөрийн чадваргүйд тооцсон үеийн ажиллагааны дэглэмийг тодорхой болгох
- Банкны Төлөөлөн удирдах зөвлөлд хараат бус мэргэжлийн этгээд байх шаардлага тавих.



Монгол Улсын Төв банкны тухай хуулийг уг хууль МБ-ны зүгээс төрийн мөнгөний бодлогыг бэхжүүлэх, инфляц/үнэ, санхүүгийн тогтвортой байдлыг хангах хараат бус бие даасан, хариуцлагатай байдлыг дэмжих ёстой гэсэн зарчимд тулгуурлан нягтлан судаллаа. Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн дараахь зөвлөмжийг өгч байна. Үүнд:

- Банкуудад олгох зээлийг хязгаарлах
- Төрийн мөнгөний бодлогыг явуулах МБ-ны хараат бус бие даасан байдлыг бэхжүүлэх зорилгоор Засгийн газарт зээл олгохыг хориглох, зээл олголтод хатуу хязгаарлалт тавих
- МБ-ны бүтцэд өндөр эрх мэдэл бүхий арилжааны банкуудын бүтцийн өөрчлөлтийн асуудал хариуцсан нэгж байгуулж ажиллуулах
- Төсөв, мөнгөний бодлогын зохицуулалттай холбоотой заалтуудыг илүү тодорхой болгох
- Ил тод байдал, харилцаа холбоо, хариуцлагыг сайжруулах заалтууд.

Монгол улсад банкны хүчтэй тогтолцоог бий болгохын тулд Банкны тухай болон Төв банкны тухай хуулиудад оруулах нэмэлт өөрчлөлтийг батлуулж, хэрэгжүүлэхээс гадна зах зээлийн зохих дэд бүтэц шаардагдаж байна. Зах зээлийн харилцаа хийгээд эрх зүйг дэмжих дэд бүтцийг дараахь арга замаар сайжруулахыг зөвлөж байна. Үүнд:

- Хувийн хэвшилд тулгуурласан зээлийн мэдээллийн сан байгуулахад ЭЗБШӨЧ төслөөс үзүүлж буй эрх зүйн болон институцийн тогтолцооны техникийн туслалцаагаа үргэлжлүүлэх
- Банкны тогтолцоонд итгэх итгэлийг хадгалж, ёс суртахууны эрсдэлээс зайлсхийх боломж олгож чадах сайтар томъёолж тодорхойлсон хадгаламжийн даатгалын тогтолцоог бий болгох эрх зүйн болон зохицуулалтын хүрээг боловсруулж, санал болгох
- Трансакцийн зардал, мэдээллийн нийцгүй байдал, "байгууллагын чанартай хүндрэлтэй асуудал" буюу ашиг сонирхлын зөрчлийг багасгах зорилгоор банкны тогтолцоонд нийтэд нь үйлчлэх зээлийн андеррайтер, зээлийн баримт бичгийн бүрдүүлэлтийг стандартчилах ажлыг үргэлжлүүлэх.

МБ дээрх зөвлөмж болон хуулиудад оруулах нэмэлт өөрчлөлтүүдийн төслийг одоогоор нягтлан судалж байгаа

бөгөөд УИХ-ын намрын чуулганаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.

Халуун сэдэв цуврал нэвтрүүлэг "Замын -Үүд: Хөгжлийн үүд"

Энэ оны 8 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд Халуун сэдэв цуврал нэвтрүүлгийн "Замын -Үүд: Хөгжлийн үүд" сэдэвт гурав дахь нэвтрүүлгийг UBS, МҮОНТ –ээр тус бүр гурван удаа дамжууллаа. БНХАУ-тай хил залгаа МУ-ын урд боомт болох Замын- Үүд дэх логистикийн асуудал, эдгээр асуудлын МУ-ын эдийн засаг, хөгжилд үзүүлэх үр нөлөөний талаар олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилгоор уг нэвтрүүлгийг хийсэн болно.

МУ-ын эдийн засгийн хөгжилд чухал ач холбогдолтой сэдвүүдийг олон нийтэд ойлгоход хялбар байдлаар хүргэх үүднээс ЭЗБШӨЧ төслөөс Халуун сэдэв цуврал нэвтрүүлгийг санаачлан гаргаж байгаа юм. Нэвтрүүлэг бүр 10-12 минут үргэлжлэх бөгөөд ярилцлага, график, зочны яриа, хөдөлгөөнт дүрс, газар дээр нь зураг авах зэрэг мэдээлэл дамжуулах чухал аргуудыг ашиглан тодорхой нэг сэдвийг онцлон нэвтрүүлдэг.

Гадаад худалдааг хөнгөвчлөх үзүүлэлтээр Монгол улс дэлхийн 181 орноос 156-д оржээ. Гол хүнсний бүтээгдэхүүнийхээ 70 хувь, аж үйлдвэрийн барааны 80 хувь, 100 хувь техник тоног төхөөрөмж, түлш шатахуун импортоор оруулдаг Монгол улсын хувьд энэ үзүүлэлтийг анхаарах шаардлагатай. Тус улсын нийт импортын 60-70 хувь нь БНХАУ-тай залгаа Замын -Үүдийн боомтоор орж ирдэг аж.



Google-д харуулсан Замын-Үүд дэх ачаа тээврийн бөөгнөрлийн газрын зураг, 2008 оны зун

Гаалийн бүрдүүлэлт, хяналт шалгалт хийх тохиромжгүй нөхцөл байдал, шилжүүлэн ачилтын шаардлага хангаагүй байгууламж, дэд бүтэц, авто замын хүнд нөхцөл зэрэг асуудлыг хөндөж уг нэвтрүүлгээр харуулав. Эдгээр асуудал нь Замын-Үүдээр дамжин өнгөрч буй ачааны мэргэжлийн хяналт тотгор учруулж бараа саатахад нөлөөлж байгаа юм. Үүнээс гадна, МУ-д уг боомтоор орж ирж буй импортын барааны энэ өндөр хувь мөн дэд бүтэцтэй холбоотой асуудлууд нь худалдаа эрхлэгчид болон тээвэр зуучдын бизнесийн зардал улмаар барааны үнэ өсөхөд нөлөөлж байна.

Замын-Үүдийн боомт дээр тулгарч буй бэрхшээлийг харуулсны дараа энэ нөхцөл байдлыг сайжруулахын тулд Засгийн газраас авч буй арга хэмжээний талаар тайлбарлаж, гааль болон мэргэжлийн хяналтын газрын мэдээлэл технологийн системийг нэгтгэж уялдуулах, барааны урсгалыг шуурхай болгох үүднээс гааль болон мэргэжлийн хяналт мөн гаалийн бүрдүүлэлтийн талбайг өргөтгөх талаар хэрэгжүүлж буй төлөвлөгөөний талаар танилцууллаа. Нэвтрүүлгийн төгсгөлд барааны урсгалыг шуурхай, илүү үр дүнтэй болгоход нөлөөлөх шилжүүлэн ачилтын шинэ байгууламжийг Замын -

Үүдэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн (ТХХТ) хэлбэрээр байгуулах боломжийн талаар тайлбар хийв.



ТХХТ-ийн хэлбэрээр байгуулах шилжүүлэн ачилтын байгууламжийн дижитал дүрс

"Замын-Үүд: Хөгжлийн үүд" нэвтрүүлэг болон Халуун сэдэв цуврал нэвтрүүлгийн бусад нэвтрүүлгийн бичлэгийг ЭЗБШӨЧ төслийн вебсайтнаас үзнэ үү (<http://www.eprc-chemonics.biz/index.php/documents/multimedia/21-multimedia.html>).

ЭЗБШӨЧ төсөл, Олон улсын санхүүгийн корпораци, МКЗХТ-ийн хамтын ажиллагаа

ЭЗБШӨЧ төсөл, Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК), Монголын Компанийн засаглалын хөгжлийн төвийн (МКЗХТ) төлөөлөгчид хэд хэдэн удаа уулзаж ярилцсаны эцэст дотоодын мэргэжилтнүүдэд зориулан сургалт явуулах, компанийн засаглалтай холбоотой материалуудыг боловсруулж нийтлэх, Дэлхийн Компанийн Засаглалын Форумын баримт бичиг, материал, ЭЗХАХБ-ын нийтлэл болон гадаадын их сургуулиудын судалгааны материал, нийтлэлийг монгол хэлнээ орчуулахад ОУСК-ийн зүгээс МКЗХТ-д туслалцаа дэмжлэг үзүүлэхээр тохиролцов. 2009 оны 9-р сарын 23-25-ны өдрүүдэд ОУСК-ийн дэмжлэгтэйгээр МКЗХТ-өөс компанийн засаглалын үнэлгээг хэрхэн хийх, олон улсын шилдэг туршлагад тулгуурлан ТУЗ-ын үнэлгээний аргачлалыг хэрхэн ашиглах талаар 3 өдрийн сургалт зохион байгууллаа. Цаашид ОУСК, ЭЗБШӨЧ төслийн зүгээс МКЗХТ-тэй нягт хамтран ажиллаж монголын байгууллагуудын чадавхийг бэхжүүлж, ур чадварыг сайжруулах хөтөлбөр боловсруулах мөн мэдлэгийн менежмент, судалгаа, сургалтын хөтөлбөр боловсруулахад техникийн туслалцаа үзүүлэх болно.

Энэхүү цуврал нь ЭЗБШӨЧ төслийн үйл ажиллагааны сар тутмын цахим хэвлэл юм. Та өөрийн санал бодол, манай цувралыг захиалах буюу захиалгаа цуцлах хүсэлтээ ЭЗБШӨЧ төслийн цуврал хариуцсан эрхлэгчид дараахь хаягаар ирүүлнэ үү.
И-мэйл fbertoli@eprc-chemonics.biz, факс: (976-11) 32 78 25.